



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 04 дүгээр сарын 25 өдөр Дугаар 11

Хэрлэн сум

ХИ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 11 дүгээр хуралдаан 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 09:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд цомхотгосон хэлбэрээр 85,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Аймгийн хэмжээнд 2023 оны 02, 03 дугаар саруудад гарсан хээрийн түймрийг унтраах ажиллагаанд байгууллага, сумдаас зарцуулсан шатах тослох материалын зардлын тооцоог танилцуулах,

Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

2.Хээрийн түймэрт дайчлан ажиллуулсан автомашинд сэлбэг хэрэгслийн дэмжлэг үзүүлэх талаар танилцуулах.

Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

3.Гамшгийн үед дайчлан ажилласан Улсын нөөцийн салбарын албан хаагч нарт урамшуулал олгох талаар санал танилцуулах

Аймгийн Засаг даргын тамгын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Санхүүгийн хяналт, аудитын албаны

дарга Б.Саранчимэг,

Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга,

Онцгой комиссын гишүүн Ц.Баяржаргал,

Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн

хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа,

Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын

хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн М.Нямсүрэн,

Аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний

хэлтсийн дарга Д.Дамдинцоо нарт:

1.1.Улсын Онцгой комиссын 01 албан даалгавар, аймгийн Засаг даргын 01 албан даалгавар, Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан бодлогын баримт бичиг, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажилд зарцуулсан төсвийн зарцуулалт, Хэрлэн сумын хяналтын цэгийн үйл ажиллагааны хэрэгжилтэд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулах,

/ М.Бадамсүрэн

/хур Г.Нармандах

Хоёр.Аймгийн Засаг даргын тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн Б.Алтансүх,
Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн
хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа,
Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн А.Гантулга нарт:

2.1.Уул уурхай, газрын тосны томоохон компаниудын төслийн талбай дээр гамшиг ослоос хамгаалах зорилгоор Байгаль хамгаалагчийг ээлжээр цалинжуулж ажиллуулах,

Аймгийн Засаг даргын тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн Б.Алтансүх,
Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн
хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа,
Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн А.Гантулга,
Байгаль хамгаалалтын захиргааны
дарга Б.Эрдэнэбаяр нарт:

2.2.Байгаль орчин, аялал жуулчлалын газар, тусгай хамгаалалттай сав газруудын захиргааны хариуцсан нутаг дэвсгэр алслагдсан газруудад хавар, намрын хуурайшилт, ан гөрөө хийх улирлуудад харуулыг томилж ажиллуулах, цалинжуулах зардлыг тооцож шийдвэрлүүлэх,

Аймгийн Засаг даргын тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн Б.Алтансүх,
Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн
хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа,
Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах нарт:

2.3.Бүтээгдэхүүн хуваах гэрээт Тамсаг 19, Тосон-Уул 21 дүгээр талбай, Меланж ХХК, Степ голд ХХК, Шинь Шинь ХХК-уудтай хамтран тухайн аж ахуйн нэгждэд хавар, намрын хуурайшилтын улиралд шуурхай бүлгийг томилгоожуулж бэлэн байдлыг хангуулахыг тус тус үүрэг болгов.

ДАРГА

М.БАДАМСҮРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ХОШУУЧ

Б.ЦОГТБАЯР

